

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ, ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2012 оны ... дугаар
сарын ...-ны өдрийн

Дугаар

Улаанбаатар
хот

Дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газар, Монголбанкны хооронд байгуулсан “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх зорилгоор Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн **ТУШААХ нь:**

Нэг. “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Дэд хөтөлбөрийн хүрээнд оролцогч банктэй гэрээ байгуулан хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавихыг Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газар /Д.Болдбаатар/-т, дэд хөтөлбөрүүдийг гардан хэрэгжүүлэгч хуулийн этгээдтэй гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавихыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Х.Золжаргал/-т тус тус үүрэг болгосугай.

Гурав. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг улирал тутам Монголбанкны Захирлуудын зөвлөл, “Мах, буудай болон газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Засгийн газрын Ажлын хэсэг”-т тус тус танилцуулахыг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн Ажлын алба /Д.Ган-Очир/, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Х.Золжаргал /-д тус тус даалгасугай.

Н. ЗОЛЖАРГАЛ

Х.БАТТУЛГА

МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ

ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ
АХУЙН САЙД

“ХҮНСНИЙ ГОЛ НЭРИЙН БАРАА, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙГ ТОГТВОРЖУУЛАХ” ДЭД ХӨТӨЛБӨР

2012 оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр¹, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэл², Монгол Улсын Засгийн газар, Монголбанкны хооронд 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичгийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүн (мах, гурил)-ий жижиглэнгийн үнийг тогтвортой байлгах зорилгоор нэг талаас Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам (ҮХААЯ), нөгөө талаас Монголбанк /хамтад нь “Талууд” гэх/ харилцан тохиролцож энэхүү дэд хөтөлбөрийг батлав.
- 1.2 Энэхүү хөтөлбөр нь хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах ойрын зорилттой, хүнсний бараа, бүтээгдэхүүний агуулахын үлдэгдлээр баталгаажих санхүүгийн хэрэгслүүдийг нэвтрүүлэн, хүнсний бараа, бүтээгдэхүүний хангамжийн зах зээлд суурилсан байнгын тогтолцоо бүрдүүлэх хэтийн зорилготой байна.
- 1.3 “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хүрээнд ерөнхий нөхцөл, хэрэгжүүлэх арга, хэрэгслийг тохиролцохын зэрэгцээ хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхойлов.
- 1.4 Хөтөлбөрийн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
 - 1.4.1 “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дэд хөтөлбөр” гэж энэ хөтөлбөрийн 1.2-т заасан зорилготой хөтөлбөрийг,
 - 1.4.2 “Жижиглэнгийн худалдааны үнэ” гэж жижиглэнгийн худалдааны байгууллагаар эцсийн хэрэглэгчдэд худалдаж буй энэ хөтөлбөрийн хүрээнд хамаарах бараа, бүтээгдэхүүний үнийг,
 - 1.4.3 “Махны нөөц” гэж зооринд хадгалж, хөнгөлөлттэй зээл авах зорилгоор махны нөөцийн менежерийн барьцаалж буй махыг,
 - 1.4.4 “Оролцогч банк” гэж уг хөтөлбөрийн санхүүжилтийг дамжуулан олгохоор зөвшөөрсөн, Монголбанкнаас сонгосон дотоодын арилжааны банкныг;
 - 1.4.5 “Монголбанкнаас тогтоосон хүү” гэж Монголбанкнаас зөвхөн энэ хөтөлбөрт зориулж үнийн тогтвортой байдалтай уялдуулан сар тутам тооцож, зарлах зээлийн хүүг;
 - 1.4.6 “Оролцогч банкны хүүний маржины дээд хязгаар” гэж Монголбанкнаас зөвхөн энэ хөтөлбөрт зориулж үнийн тогтвортой байдалтай уялдуулан сар тутам тооцож, зарлах оролцогч банкны нэмэх хүүний дээд хязгаарыг;
 - 1.4.7 “Махны нөөцийн менежер” гэж тогтоосон шалгуур үзүүлэлтийн дагуу ҮХААЯ-наас сонгон шалгаруулсан хуулийн этгээдийг,

1 Инфляцид хөтлөгдөх бус зохирулдаг тогтолцоонд ишлжих, инфляцийг нэг оронтой тоонд барьж, төгрөгийн худалдан авах чадварыг тогтвортой байлгах, мах махан бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах зорилгоор махны нийлүүлэлтийн шинэ тогтолцоог бүрдүүлнэ.

2 Мөнгөний бодлогын арга хэрэгслээр инфляцийг тогтвортой нам түвшинд байлгаж, Засгийн газартай хамтран нийлүүлэлтийн гаралтай инфляцийн нөлөөллийг хязгаарлах бодлого баримтална. Инфляцийг 2013 оны эцэст 8 хувиас хэтрүүлэхгүй байж, улмаар 2014-2015 онд 5-7 хувийн түвшинд байлгана.

1.4.8 “Хөтөлбөрийг гардан хэрэгжүүлэгч” гэж “Махны нөөц бүрдүүлэх, үнийг тогтворжуулах” хөтөлбөрийн хувьд махны нөөцийн менежер, Гурилын үнийг тогтворжуулах” хөтөлбөрийн хувьд гурилын үйлдвэрүүд, “Хүнсний бүтээгдэхүүний зоорь, агуулахыг нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх” хөтөлбөрийн хувьд ҮХААЯ-наас сонгон шалгаруулсан хуулийн этгээдийг.

Хоёр. “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг болон хэрэгжүүлэх арга, хэрэгсэл

2.1 “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрт дараах хөтөлбөрүүд багтана:

2.1.1 Махны нөөцийн менежерт хөнгөлөлттэй эргэлтийн зээл олгож, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах замаар махны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах нөхцөлийг тогтмол хангах зорилго бүхий “Махны нөөц бүрдүүлэх, үнийг тогтворжуулах” хөтөлбөр;

2.1.2 Гурилын үйлдвэрүүдэд шинэ ургацын хүнсний буудай худалдан авахад хөнгөлөлттэй зээлийг олгох замаар гурилын жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах нөхцөлийг тогтмол хангах зорилго бүхий “Гурилын үнийг тогтворжуулах” хөтөлбөр;

2.1.3 Хүнсний зориулалттай зоорь, агуулах барих сонирхолтой хувийн хэвшилд хөнгөлөлттэй зээл олгох замаар стандартын шаардлага хангасан олон тооны зоорь, агуулах барих нөхцөлийг бүрдүүлэх зорилго бүхий “Хүнсний бүтээгдэхүүний зоорь, агуулахыг нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх” хөтөлбөр.

2.2 Хэрэгжүүлэх арга, хэрэгсэл:

- “Махны нөөц бүрдүүлэх, үнийг тогтворжуулах” хөтөлбөрийн хувьд:
 - Нөөцийн менежерт зоорин дахь махны нөөцийг барьцаанд тооцуулан эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээл авах боломжийг олгоно.
- “Гурилын үнийг тогтворжуулах” хөтөлбөрийн хувьд:
 - Гурилын үйлдвэрүүд үр тарианы нөөцөө барьцаанд тооцуулан эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээл авч, гурилын үйлдвэрлэлээ тогтвортой байлгах боломжийг бүрдүүлнэ.
- “Хүнсний бүтээгдэхүүний зоорь, агуулахыг нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх” хөтөлбөрийн хувьд дараах боломжийг хувийн хэвшилд олгоно:
 - Шинээр барих, өргөтгөл хийх стандартын шаардлага хангасан, хүнсний зориулалттай зоорь, агуулах болон зоорь, агуулах бүхий худалдааны төвийг барьцаанд тооцуулан хөнгөлөлттэй зээл авах;
 - Мах, сүү болон хүнсний ногоо үйлдвэрлэгч эрчимжсэн аж ахуйн үл хөдлөх хөрөнгө болон бусад хөрөнгийг барьцаанд тооцуулан хөнгөлөлттэй зээл авах.

2.3 Хэрэгжүүлэх хугацаа: 3 жил

2.4 Санхүүжилтийн нийт дүн: Дэд хөтөлбөр тус бүрийн санхүүжилтийн нийлбэр байна. Дэд хөтөлбөр тус бүрийн хувьд дараах хэмжээний санхүүжилтийн шугам нээнэ:

- “Махны нөөц бүрдүүлэх, үнийг тогтворжуулах” хөтөлбөр: нийт 87,000,000,000.0 /Наян долоон тэрбум төгрөг/;
- “Гурилын үнийг тогтворжуулах” хөтөлбөр: нийт 61,000,000,000.0 /Жаран нэгэн тэрбум төгрөг/;

- “Хүнсний бүтээгдэхүүний зoorь, агуулахыг нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх” хөтөлбөр: нийт 100,000,000,000.0 /Нэг зуун тэрбум төгрөг/;

2.5 Үр дүн: 1/ Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн урт хугацааны тогтвортой байдлыг хангах суурь тогтолцоо бүрдэнэ. 2/ хөтөлбөрт хамрагдсан гол нэрийн бүтээгдэхүүний жижиглэнгийн худалдааны үнэ тогтвортой байх боломж бүрдэнэ.

2.6 Монголбанкны хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.6.1 Энэхүү гэрээний 2-т заасан “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг болон хэрэгжүүлэх арга, хэрэгсэлд нэмэлт, өөрчлөлт оруулах, хөтөлбөрийг дуусгавар болгох, үргэлжлүүлэх асуудлыг ҮХААЯ-тай хамтран шийдвэрлэнэ.

2.6.2 Дэд хөтөлбөрт оролцогч банкны хүсэлтийг хянаж, зөвшөөрөл олгож, гэрээ байгуулна.

2.6.3 ҮХААЯ-наас сонгон шалгаруулсан хөтөлбөрийг гардан хэрэгжүүлэгчид дараах нөхцөлтэй хөтөлбөрийн санхүүжилтийг оролцогч банкаар дамжуулан олгоно:

- | | |
|---------------------------|---|
| - Зээлийн зориулалт: | 2.1-д заасан хөтөлбөрүүдийн санхүүжилт |
| - Зээлийн төрөл: | Засгийн газартай хамтран хэрэгжүүлэх хөтөлбөр |
| - Зээлийн хүү: | Монголбанкнаас тогтоосон хүү+оролцогч банкны хүүний маржины дээд хязгаар |
| - Зээлийн эрхийн хугацаа: | 3 жил хүртэл |
| - Зээлийн барьцаа: | Тухайн хөтөлбөрөөс хамаарна (Тухайлбал, мах, үр тариа, барьж буй зoorь, агуулах, үл хөдлөх хөрөнгө болон бусад хөрөнгө ³) |
| - Үйлчилгээний шимтгэл: | Оролцогч банктай тохиролцоно |

2.6.4 Оролцогч банктай байгуулсан гэрээндээ тогтмол хяналт тавьж, санхүүжилтийн нэгдсэн мэдээг сар тутам гаргаж, нийтэд мэдээлнэ.

2.6.5 Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтвортой байдлыг найдвартай хангах зохион байгуулалтын ажлыг ҮХААЯ-тай хамтран хэрэгжүүлнэ.

2.7 Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.7.1 Энэхүү хөтөлбөрийн 2.1-д заасан хөтөлбөр тус бүрийг гардан хэрэгжүүлэгч хуулийн этгээдийг сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлт, нөөц хадгалах зoorь, агуулахад тавигдах стандарт болон хөтөлбөрт хамрагдах бараа, бүтээгдэхүүний чанарын стандартыг тус тус тогтооно.

2.7.2 Хөтөлбөр тус бүрийн хувьд гардан хэрэгжүүлэгчийг хуульд нийцүүлэн сонгон шалгаруулж, дараах нөхцөлийг тусгасан гэрээ байгуулна:

- Жижиглэнгийн борлуулалтын үнийг тогтвортой байлгах⁴,

³ Зээлийн барьцааны үнийн дүнгийн тодорхой хувьтай тэнцэх хэмжээнд нь зээл олгоно.

- Стандартын шаардлага хангасан бараа, бүтээгдэхүүнийг нийлүүлэх,
 - Зээлийг зөвхөн зориулалтын дагуу ашиглах,
 - Оролцогч банкны зээлийн ерөнхий шаардлагыг хангах,
 - Үнийн өөрчлөлтөөс шалтгаалан үүсч болзошгүй аливаа эрсдэлийг хөтөлбөрийг гардан хэрэгжүүлэгч өөрөө хариуцахыг тохиролцох,
 - Бүтээгдэхүүний чанарын асуудалд тогтмол хяналт тавьж, үүсэх эрсдэлийг дангаар хариуцахаар хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээдтэй тохиролцох,
 - Гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд хуулийн дагуу арга хэмжээ авах.
- 2.7.3 Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтвортой байдлыг найдвартай хангах зохион байгуулалтын ажлыг Засгийн газар, хувийн хэвшил болон төрийн бус байгууллагатай тохиролцож, Монголбанктай хамтран хэрэгжүүлнэ. Үүнд: агуулахад хадгалагдаж буй хөдлөх эд хөрөнгө (мах, гурил болон бусад)-өө барьцаалан санхүүгийн байгууллагаас зах зээлийн механизмаар зээл авах боломжийг бүрдүүлэх асуудал хамаарна.
- 2.7.4 Дэд хөтөлбөрийн бүхий л үйл ажиллагаа (хөтөлбөрийг гардан хэрэгжүүлэгчид санхүүжилт олгохоос бусад)-ны хэрэгжилтийг зохион байгуулна.
- 2.7.5 Дэд хөтөлбөрийг гардан хэрэгжүүлэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтэд холбогдох байгууллага (Онцгой байдлын ерөнхий газрын Улсын нөөцийн газар, Нийслэлийн засаг даргын тамгын газар, Мэргэжлийн хяналтын газар, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг болон бусад)-тай хамтран тогтмол хяналт тавьж, газар дээрх шалгалт хийнэ.
- 2.7.6 Нөөцийн мах бэлтгэл, түүний жижиглэнгийн худалдааны үнийн мэдээллийг ил тод байлгаж, нөөцийн махны жижиглэнгийн худалдааны үнэд тогтмол хяналт тавьж ажиллана.
- 2.7.7 Монгол Улсын хэмжээгээр мах, гурилын нөөцийн хэмжээг улсын болон хувийн сектороор болон нийслэл, аймагаар улирал бүр гаргаж, нийтэд мэдээлнэ.

Гурав. Монголбанкны чиг үүрэг

- 3.1 Оролцогч банкны жагсаалтыг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах,
- 3.2 Тухайн нэг хөтөлбөрийн хувьд оролцогч банкинд олгох зээлийн дээд хэмжээ, Монголбанкнаас тогтоосон хүү болон оролцогч банкны хүүний маржины дээд хязгаарыг сар тутам тогтоож, зарлах,
- 3.3 Зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан энэхүү хөтөлбөрийн 2.6.3-т заасан санхүүжилтийн нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийг гаргах,
- 3.4 Энэхүү хөтөлбөрийн 2.7.2 заалтын дагуу байгуулах гэрээний төсөлд санал өгөх, байгуулсан гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтийг хүргүүлж, шийдвэрлүүлэх,
- 3.5 Энэхүү хөтөлбөрийн 2.6.1 заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор 1/ ҮХААЯ-аас мэдээ, мэдээлэл, тайлбарыг гаргуулан авах, 2/ холбогдох саналаа хүргүүлснээс хойш ажлын 10 хоногийн дотор хариу өгөөгүй тохиолдолд Монголбанкны саналыг дэмжсэнд тооцож, хэрэгжилтийг хангуулах,
- 3.6 Хөтөлбөрийн хүрээнд оролцогч банкинд олгосон нийт зээлийн дүнг дунд хугацааны Засгийн газрын үнэт цаасаар солих,

⁴ Гадаад, дотоод зах зээлд огцом өөрчлөлт ороогүй нөхцөлд

- 3.7 Оролцогч банктай байгуулсан гэрээгээ биелүүлээгүй хөтөлбөрийг гардан хэрэгжүүлэгчийг хөтөлбөрөөс хасуулах, хуулийн дагуу арга хэмжээ авах саналыг ҮХААЯ-д хүргүүлж, шийдвэрлүүлэх,
- 3.8 Мах, гурилын үнийг тогтворжуулах чиглэлээр хэрэгжиж буй болон хэрэгжүүлэхээр төлөвлөж буй бодлого, төсөл, хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг ҮХААЯ-аас авах,
- 3.9 Үр тариа, махны нөөцөд болон гурилын нийлүүлэлтэд гарч буй өөрчлөлт, тэдгээрийн жижиглэнгийн худалдааны үнийн талаарх мэдээллийг тухай бүр ҮХААЯ-аас авах,
- 3.10 Оролцогч банкнаас ирүүлсэн зээлийн хүсэлт, зээлийн хорооны хурлын шийдвэр, өмнөх зээлийн ашиглалтын тайлан зэрэг баримтыг үндэслэн оролцогч банкинд хөтөлбөрийн зориулалтаар зээл олгоно.
- 3.11 Оролцогч банкнаас хөтөлбөрийн зээлийн ашиглалт болон эргэн төлөлтийн талаарх тайлан мэдээг сар бүр авч, нийтэд мэдээлнэ.
- 3.12 ҮХААЯ-ны хүсэлтийн дагуу оролцогч банктай холбоотой асуудлыг судлан шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд хэсэгчилсэн шалгалтыг зохион байгуулна.
- 3.13 “Хөдлөх эд хөрөнгийн болон түүнтэй холбоотой эрхийн барьцааны тухай” хуулийн төслийг бэлтгэхэд хамтран ажиллаж, энэхүү хөтөлбөрийн 1.2 заалт дахь хэтийн зорилтыг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 3.14 Энэхүү хөтөлбөрийн 4.7 дах заалтыг хэрэгжүүлэх тооцоо, судалгаа гаргахад оролцоно.

Дөрөв. Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны чиг үүрэг

- 4.1 Энэхүү хөтөлбөрийн 2.4.1 дэх заалтыг Монголбанктай хамтран хэрэгжүүлэх,
- 4.2 Хөтөлбөрийн хүрээнд Монголбанкны хариуцан гүйцэтгэж буй үйл ажиллагаатай холбоотой асуудлаар хөтөлбөрийг гардан хэрэгжүүлэгчийн тавьж буй саналыг Монголбанкинд уламжилж, шийдвэрлүүлэх,
- 4.3 Монголбанкнаас оролцогч банкуудтай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавихад төлөөллөө оролцуулах,
- 4.4 Дэд хөтөлбөрийн 2.7.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор хөтөлбөрийг гардан хэрэгжүүлэгч хуулийн дагуу хариуцлага хүлээх эрх зүйн орчныг бүрдүүлэх,
- 4.5 Махны үнийн хэт хэлбэлзлээс зайлсхийх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх,
- 4.6 Эрүүл ахуйн шаардлагад нийцсэн зоорь, агуулахад тогтоосон стандартыг хангасан мах, үр тарианы нөөц бүрдүүлж, хяналт тавих,
- 4.7 Махны нөөцийн жижиглэнгийн худалдааны үнийг төрийн холбогдох байгууллагатай хамтран тус тус тогтоох,
- 4.8 Махны нөөц бэлтгэх үйл ажиллагааг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах,

- 4.9 Зах зээл дээрх махны нийлүүлэлтийг хянах замаар махны нөөцийг хэзээ, аль цэгүүдээр худалдаалах шийдвэрийг холбогдох байгууллагатай хамтран гаргаж, хэрэгжүүлэх,
- 4.10 Хөтөлбөрийн 2.7.2 дахь заалтыг хэрэгжүүлэхдээ Монголбанкнаас санал авах,
- 4.11 Үр тариа, махны нөөцийн болон гурилын нийлүүлэлтийн хэмжээнд гарч буй өөрчлөлтийг тухай бүр бүртгэх, нэгтгэх болон Монголбанкинд хүргүүлэх зааврыг батлан мөрдүүлэх,
- 4.12 Энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг сар бүр нийтэд мэдээлж байх,
- 4.13 Энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд нөлөөлөхүйц бодлогын шийдвэр гаргахдаа Монголбанктай зөвшилцөх,
- 4.14 Махны жижиглэнгийн худалдааны зах зээлийн дараах мэдээллийг ил тод, нээлттэй болгоно:
- Махны нөөц бүрдүүлэхэд худалдан авах үнэ
 - Махны нөөц бүрдүүлэх, худалдаалах механизм
 - Махны нөөцөөс худалдаанд гаргаж буй махны хэмжээ
 - Махны экспортын хэмжээ (махны төрөл бүрээр)
 - Махны нөөцийг худалдах үед түүний үнийг тухай бүр мэдээлэх
 - Махны борлуулалт эрхэлж буй иргэн, хуулийн этгээдийн жагсаалт /жижиглэнгийн болон бөөний/
- 4.15 Мах, гурил болон хүнсний ногооны балансыг мэдээлэл шинэчлэгдэх тухай бүр Монголбанкинд ирүүлэх,
- 4.16 Засгийн газраас хүнс, хөдөө аж ахуйн салбарт авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээ, түүний хүлээгдэж буй үр дүн, тооцоо үндэслэлийг тухай бүр Монголбанкинд ирүүлэх,
- 4.17 Энэхүү дэд хөтөлбөрийн хавсралтад заасан бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг улирал тутам мэдээлэх,
- 4.18 ҮХААЯ нь дэд хөтөлбөр хэрэгжих хугацаанд хавсралтад заасан бодлогын дунд хугацааны зорилтод хүрээгүй нь хөтөлбөр цуцлагдах үндэслэл болох бөгөөд гарах үр дагаврыг ҮХААЯ хариуцна.
- 4.19 “Хөдлөх эд хөрөнгийн болон түүнтэй холбоотой эрхийн барьцааны тухай” хуулийн төслийг бэлтгэхэд хамтран ажиллаж, энэхүү хөтөлбөрийн 1.2 дахь заалт дахь хэтийн зорилтыг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Тав. Хөтөлбөрийг сурталчлах

- 5.1 ҮХААЯ болон Монголбанк хөтөлбөрийн зорилго, үр дүнгийн хэрэгжилтийг улирал тутам нийтэд мэдээлнэ.

Бодлогын зорилт

Зорилт	Хэрэгжүүлэх механизм	Хугацаа
Махны чиглэлийн аж ахуй үүсгэн байгуулах сонирхлыг бий болгох	Төвлөрсөн зах зээлд 2-7 дугаар сард мал нийлүүлсэн малчдад урамшуулал олгох тогтолцоог бий болгох	Дунд хугацаанд
Дотоодын зах зээл дэх махны нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах	Тухайн жилийн махны баланс, инфляцийн түвшинг харгалзан, махны нийлүүлэлт багасдаг 4-7 дугаар сард АА, ААА зэрэглэл бүхий махны үйлдвэрүүдийн экспортын хэмжээнд хязгаарлалт тогтоох	
Улсын махны зоорьтой болох	Орчин үеийн технологи бүхий махны зоорийн аж ахуйг төрийн өмчит компани хэлбэрээр байгуулах (10 мян.тн-ын багтаамжтай махны зоорийг БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Эмээлтэд байгуулах)	
Мал сүргийн зохистой бүтцийг бүрдүүлэх	Малчдын нийгмийн хариуцлагыг өндөржүүлж, бэлчээр болон мал сүргийн зохистой бүтцийг бүрдүүлэх зорилгоор бэлчээрийн татварыг малын тоо, настай нь уялдуулж тогтоох	Урт хугацаанд
Мал нядалгааны цехүүдийг нэмэгдүүлэх	Дэлхийн хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас гаргасан зөвлөмжийн дагуу мал нядалгааны цехүүдийг орон нутагт байгуулахад техникийн туслалцаа, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих	